



Монгол улсад тороос хvн амын эрvл мэндийг сайжруулах талаар хэрэгжvлж буй олон арга хэмжээний дунд сvвлийн жилvвдэд нялхсын эндэгдэл ондор хэвээр байна. Нярай эндэгдэлийг бууруулахад торох ороонд эх барихын тусламж вйлчилгээ vзвvлэгч эх баригч, эмнэлгийн мэргэжилтнvвдийн мэдлэг, ур чадвар, хандлагыг оорчлох, ялангуяа нярайн сэхээн амьдруулалтын ур чдварыг эзэмшvлэх дадлага, сургалт явуулах зайлшгvй шаардлагатай байна.

Энэхvв шаардлагын хvрээнд Олон улсын Ротари сан, Япон улсын Гинован Ротари, Ёкохама-Каназава Ротари, Монгол улсын Туул Ротари клуб, Монголын эх баригчдын нийгэмлэг хамтран “Happy birth and Happy baby” тослийг хэрэгжvлэхээр эхэллээ.

Тослийн нээлтийн вйл ажиллагаа 2019.09.14-ний одор Бямба гаригийн 10:00 цагт Блюскай кочид буудлын “Кристал” танхимд болж ЭХЭМҮТ, 21 аймгийн Эрvл мэндийн газар, Нийслэлийн Оргоо амаржих газар, Хvрээ амаржих газар, Амгалан амаржих газрын дарга нарт Япон улсын Кокен брэндийн ондор хvчин чадалтай нярайн сэхээн амьдруулалтын муляжийг дагалдах хэрэгсэлийн хамтаар гардуулан оглоо.

Тослийн албан ёсны нээлтэнд Японы Гинован, Ёкохама-Каназава клубын ротаричууд, тослийг хэрэгжvлэгч Туул ротари клубын ротаричууд, Япон улсын элчин сайдын яамны толоол, Японы эх баригчдын нийгэмлэгийн толоолол, Монголын эх баригчдын нийгэмлэгийг толоолол, албаны бусад хvмvвс оролцлоо.

Тослийн хvрээнд Эх баригч сургагч багш бэлтгэх “Нярайн зvрх, уушигны амилуулах тусламж” сэдэвт сургалтыг 2019 оны 9-р сарын 16-аас 19-ний одрvвдэд зохион байгуулж

байна.